



НИЙСЛЭЛИЙН ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙН ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2021 оны 05 сарын 06 өдөр

Дугаар А/09

Улаанбаатар хот

Хөдөлмөр эрхлэлтийн цахим өдөрлөг зохион байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, 16 дугаар зүйлийн 16.5.5, Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.2.1, 6 дугаар зүйлийн 6.1.1, 29 дүгээр зүйлийн 29.9.6, 29.13.4, Хөдөлмөр эрхлэлтийн нийслэлийн зөвлөлийн 2021 оны 01 дүгээр тогтоол, Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газрын 2021 оны А/58 дугаар тушаалыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Цар тахлын нөхцөл байдлаас шалтгаалан гадаад улсаас эх орондоо эргэн ирсэн иргэд болон ажил хайгч иргэд, оюутан залуучуудад зориулан хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээ, арга хэмжээг цахимаар нэг дороос үзүүлэх “Хөдөлмөр эрхлэлтийн цахим өдөрлөг”-ийг 2021 оны 05 дугаар сарын 08-ны өдрөөс 2021 оны 05 дугаар сарын 24-ний өдрийг дуустал хугацаанд “Сageer exro” платформ дээр зохион байгуулсугай.

2. “Хөдөлмөр эрхлэлтийн цахим өдөрлөг” зохион байгуулах удирдамжийг нэгдүгээр, нэгдсэн төсвийг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

3. Цахим өдөрлөг зохион байгуулахад шаардагдах 34.990.000 /гучин дөрвөн сая есөн зуун ерэн мянган/ төгрөгийг холбогдох зардлаас гаргахыг Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан хариуцсан нягтлан бодогч /Т.Лхагва/-д зөвшөөрсүгэй.

4. Цахим өдөрлөгийг заасан хугацаанд зохион байгуулж, үр дүнг танилцуулж ажиллахыг Хөдөлмөр эрхлэлтийн хэлтэс /Г.Ганзориг/-т үүрэг болгосугай.

ДАРГА



С.НЯМДОРЖ

1150600015

Нийслэлийн хөдөлмөр эрхлэлтийн газрын даргын
2021 оны 05 дугаар сарын 06-ны өдрийн 1109
дугаар тушаалын 1 дүгээр хавсралт



**“ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙН ЦАХИМ ӨДӨРЛӨГ”
ЗОХИОН БАЙГУУЛАХ УДИРДАМЖ**

Нэг. Зорилго

Цар тахлын нөхцөл байдалтай холбогдуулан гадаад улсаас эх орондоо эргэн ирсэн иргэдэд зориулан хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээ, арга хэмжээ, зөвлөгөө мэдээллийг нэг дороос үзүүлэх, ажил олгогчоос ирүүлсэн нээлттэй ажлын байрны мэдээллийг ажил хайгч иргэдэд танилцуулах, ажлын ярилцлагад цахимаар хамруулах, төр, хувийн хэвшлийн хамтын ажиллагааг сайжруулах, ажил олгогчид шаардлагатай ажиллах хүчээ олоход нь дэмжлэг үзүүлэхэд оршино.

Хоёр. Зохион байгуулагч талууд:

- Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам
- Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газар
- Нийслэлийн Хөдөлмөр эрхлэлтийн газар
- Эйч Ар клуб ТББ

Гурав. Оролцогч:

- Гадаад харилцааны яам
- Хөгжлийн бэрхшээлтэй иргэний хөгжлийн ерөнхий газар
- Нийгмийн даатгалын ерөнхий газар
- Дүүргийн хөдөлмөр, халамжийн үйлчилгээний хэлтэс
- Хөдөлмөрийн хувийн бирж
- Мэргэжлийн холбоод
- Ажил олгогчид
- Бусад талууд

Дөрөв. Хугацаа, байршил:

Өдөрлөг 2021 оны 05 дугаар сарын 08-ны өдрөөс 2021 оны 05 дугаар сарын 24-ний өдрүүдэд career expo платформ дээр зохион байгуулагдана.

Тав. Зохион байгуулагдах үйл ажиллагаа

- Зохистой хөдөлмөр эрхлэлтийн талаарх ойлголт
- Ковид ба хөдөлмөр эрхлэлт, ажлын байрны чиг хандлага “Цахим ажлын байр”
- Залуучуудын хөдөлмөр эрхлэлт
- Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйлчилгээ, арга хэмжээ
- Гадаадаас буцан ирсэн иргэдийн мэдээлэл
- Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлт
- Бичил бизнес эрхлэгчдийг дэмжих арга хэмжээ

- Ажил олгогчдын нээлттэй ажлын байрны мэдээллийг иргэдэд цахимаар хүргэх
- Мэргэшсэн хүний нөөцийн ажилтнууд, мэргэжлийн сэтгэл зүйч, ажил мэргэжлийн чиг баримжаа олгох мэргэшсэн зөвлөхүүд ажил горилогчдод ажилд ороход шаардлагатай анхан шатны мэдлэг олгох зөвлөгөө, мэдээлэл өгөх
- Ажил хайгч иргэн холбогдох цэсүүдэд хандан, анкет бөглөх, анхан шатны ярилцлагад орох
- Ажил олгогч нар ажил хайгч иргэдийн анкет мэдээлэлтэй танилцах, анхан шатны ажлын ярилцлага хийх
- Чиглэл тус бүрээр нээлттэй хариулт өгөх хөтөч ажиллуулах

Зургаа. Цахим өдөрлөгийн зохион байгуулалт

Сageer exro платформд суурилна.

Ажил олгогч:

- ✓ Бүртгүүлэх
- ✓ Ажил олгогчдын сул чөлөөтэй нээлттэй ажлын байрны захиалга танилцуулах
- ✓ Ажил олгогчдод ирүүлсэн ажил хайгч иргэдийн анкетаас урьдчилсан сонгон шалгаруулалт хийж, анхан шатны ажлын ярилцлагыг цахимаар зохион байгуулах

Ажил хайгч:

- ✓ Бүртгүүлэх
- ✓ Ажил хайгч иргэд анкет бөглөх
- ✓ Өөрт тохирох ажлын байрны сонгон шалгаруулалтад анкет илгээх
- ✓ Ажлын анхан шатны ярилцлагад цахимаар оролцох
- ✓ Хөдөлмөр эрхлэлтийн мэдээлэл, хөтөлбөр арга хэмжээний талаарх мэдээлэлтэй танилцах

Зөвлөгөө мэдээлэл:

- ✓ Мэргэшсэн зөвлөх, сургагч багш нар иргэдэд ажил мэргэжлийн чиг баримжаа олгох, зөвлөх үйлчилгээг цахимаар үзүүлэх
- ✓ Хөдөлмөрийн харилцаа, хөдөлмөрийн маргаантай холбоотой сэдвээр иргэдэд зөвлөн туслах үйлчилгээг цахимаар үзүүлэх
- ✓ Мэргэжлийн сэтгэл зүйчид иргэдэд сэтгэл зүйн оношилгоо хийж зөвлөгөө өгөх

Танин мэдэхүй:

- ✓ Хөдөлмөрийн тухай, Нийгмийн даатгалын тухай, Эрүүл мэндийн даатгалын тухай хуулиуд, Монгол улсын Засгийн газраас хэрэгжүүлж буй төсөл хөтөлбөрүүдийн мэдээлэл, сонирхолтой мэдээ, мэдээлэл, сургалт

Гарааны бизнес эрхлэгчдийн үзэсгэлэн худалдаа:

- ✓ Үзэсгэлэн худалдаа
- ✓ Гарааны бизнесийн тухай мэдээлэл

Долоо. Цахим өдөрлөгийн үр дүн

Иргэд, аж ахуйн нэгж байгууллагууд Хөдөлмөр нийгмийн хамгааллын яамны харьяа байгууллагуудаас хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээ, арга хэмжээ болон нийгмийн даатгалын үйлчилгээг нэг дороос цахимаар авч, мэдээ мэдээллээр хангагдсан байна.

Нийслэлийн хөдөлмөр эрхлэлтийн газрын даргын
2021 оны 05 дугаар сарын 06 ны өдрийн А/05
дугаар тушаалын 2 дугаар хавсралт



“ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙН ЦАХИМ ӨДӨРЛӨГ”-ИЙН НЭГДСЭН ТӨСӨВ

№	Зардлын зүйл	Хэмжих нэгж	Тоо ширхэг	Нэгжийн үнэ	Нийт үнэ
1	Виртуал үзэсгэлэнгийн лобби үүсгэж хөгжүүлэх	удаа	1	6.000.000	6.000.000
2	3D бүүт бүхий үзэсгэлэнгийн танхим хийх	удаа	1	3.500.000	3.500.000
3	Бүртгэлийн модулийн форм хийх	удаа	1	1.500.000	1.500.000
4	Платформ дээр хурлын дамжуулалтын 1-3 цахим өрөө үүсгэж, шууд дамжуулалтыг холбож хурлын дамжуулалтын турш хянах	удаа	1	3.200.000	3.200.000
5	Олон улсын албан ёсны Vimeo суваг дээр байршуулах	удаа	1	990.000	990.000
6	Танилцуулга цэс дотор нэгж мэдээлэл дээр дарахад тухайн хүний дэлгэрэнгүй мэдээлэл харагдах боломжтой байхаар холболт хийх	удаа	1	1.200.000	1.200.000
7	Платформын нэгдсэн хандалтын статистик гаргах функц хөгжүүлэх	удаа	1	1.200.000	1.200.000
8	Платформд хөтөлбөрийн мэдээллийг байршуулах	7 хоног	2	450.000	900.000
9	Бүх арга хэмжээний туршид оролцох илтгэгчдийн танилцуулгыг хурлын танхимд байршуулж бэлтгэх	7 хоног	2	300.000	600.000
10	Зөвлөгөө өгөх уулзалтын танхим, энтертаймент танхимуудыг бэлтгэж удирдах	удаа	1	1.350.000	1.350.000
11	Нэгдсэн платформыг өндөр хүчин чадалтай серверт байршуулах	удаа	1	1.250.000	1.250.000
12	Үзэсгэлэнгийн нүүр хуудас дээр танилцуулга мэдээлэл бэлтгэж оруулах	удаа	1	850.000	850.000

	мэдээллийн аюулгүй байдлыг хангах				
14	HR клубтэй хамтран ажил олгогчдыг нэгдсэн байдлаар хамруулах, ажлын ярилцлагыг зохион байгуулах	удаа	1	2.500.000	2.500.000
15	Өдөрлөгийн видео танилцуулга бэлтгэх, цацах	удаа	1	2.500.000	2.500.000
16	Хэлэлцүүлэгт панелистаар оролцох хувийн хэвшлийн төлөөлөлд урамшуулал олгох	хүн	15	100.000	1.500.000
17	Цахим өдөрлөгийн лого дизайн, баннерын эх бэлтгэх	удаа	1	500.000	500.000
18	Харилцаа холбооны зардал	хүн	8	25.000	200.000
19	Нийгмийн сүлжээгээр цахим өдөрлөгийн сурталчилгаа хийх	удаа	1	500.000	500.000
20	Өдөрлөгийн бичиг хэрэг, бэлтгэл ажил, нэгдсэн хурлын зардал	удаа	1	600.000	600.000
21	ФМ, радиогоор цахим өдөрлөгийн мэдээлэл хийх	удаа	1	200.000	200.000
22	Бусад	удаа	1	1.500.000	1.500.000
Нийт					34.990.000